



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/212

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны ... дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Говь-Алтай аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын Монгол хэлний багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтын зардалд шаардагдах 3,200,000 (гурван сая хоёр зуун мянга) төгрөг, Баруун бүсийн орос, англи хэлний багш нарын эрдэм шинжилгээний зөвөлгөөнд оролцох багш нарын сургалтын зардалд 4,500,000.00 (дөрвөн сая таван зуун мянга) төгрөг, Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын Агуулга хөгжүүлэх, арга зүй сэдэвт сургалтад хамрагдах багш нарын сургалтын зардалд 2,000,000, (хоёр сая) төгрөг нийт 9,700,000 (есөн сая долоон зуун мянга) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж Боловсрол шинжлэх ухааны газар (Ж. Амгаланбаатар) –т шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат) –т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



